



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

**Нийслэлийн Ерөнхий боловсролын
129 дүгээр сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
балансаас баланст шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Нийслэлийн Ерөнхий боловсролын 129 дүгээр сургуулийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,150,000 (таван сая нэг зуун тавин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг балансаас баланст шилжүүлсүгэй.

2.Балансаас баланст шилжүүлж буй дээрх хөрөнгийг данс бүртгэлээсээ хасахыг нийслэлийн Ерөнхий боловсролын 129 дүгээр сургууль (Д.Бат-Отгон)-д, шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж авахыг нийслэлийн Ерөнхий боловсролын 162 дугаар сургууль (С.Чулуунбилэг)-д тус тус даалгасугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийхийг нийслэлийн Ерөнхий боловсролын 129 сургууль (Д.Бат-Отгон)-д, нийслэлийн Ерөнхий боловсролын 162 дугаар сургууль (С.Чулуунбилэг)-д тус тус үүрэг болгосугай.


4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Ц.Цэрэндулам)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2023 оны ...07 дугаар сарын 25 өдрийн
 А/..... дугаар тушаалын хавсралт



Балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Ерөнхий боловсролын 129 дүгээр сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ (төгрөгөөр)		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Шилжүүлэн авах байгууллага			
									нэгж үнэ	нийт үнэ						
1	Азонжуулагч цэвэрлэгч төхөөрөмж	Хятад	220V 1.5 KB	2022	2022	сайн	Ш	1	3,400,000	3,400,000	170,000.01	3,229,999.99	Нийслэлийн Ерөнхий боловсролын 162 дугаар сургууль			
2	Хөргөгч 4 хаалгатай	LC-SMBG01	220V	2022	2022	сайн	Ш	1	1,750,000	1,750,000	87,500.01	1,662,499.99				
Балансаас баланст шилжүүлэх тоног төхөөрөмжийн дүн													5,150,000	257,500.02	4,892,499.98	